



ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/153

Улаанбаатар хот

Загвар батлах тухай

Монгол Улсын яамны эрхзүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, 9.8 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 272 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.4.20 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Зорчих зөвшөөрөл хүсэх тухай мэдэгдэх хуудас”-ны загварыг хавсралтаар баталсугай.

2. Зорчих зөвшөөрөл хүсэх тухай мэдэгдэх хуудсыг загварын дагуу зорчихоос ажлын 3 өдрийн өмнө Дипломат төлөөлөгчийн газрын цахим шуудангаар Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж, холбогдох зөвшөөрлийг авч байхыг нийт Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт үүрэг болгосугай.

3. Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй албан хаагчдын зорчих хөдөлгөөний нэгдсэн бүртгэл хөтөлж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын захирал С.Золжаргалд даалгасугай.


4. Энэ тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Н.АНХБАЯР

102211565



ЗОРЧИХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ТУХАЙ МЭДЭГДЭХ ХУУДАС		
1	Эцэг /эх/-ийн нэр, нэр:	
2	ДТГ:	
3	Албан тушаал:	
4	Гадаад паспортын дугаар:	
5	Зориулалт:	Ээлжийн амралт: <input type="checkbox"/>
		Албан хэргээр: <input type="checkbox"/>
		Хувийн хэргээр: <input type="checkbox"/>
6	Хугацаа:	Эхлэх өдөр: ____/____/____
		Дуусах өдөр: ____/____/____
7	Хаашаа:	Эх орондоо: <input type="checkbox"/>
		Бусад улс: <input type="checkbox"/> : _____
8	Зөвшөөрөл хүссэн бүртгэлийн дугаар:	
9	Зөвшөөрөл хүссэн бүртгэлийн огноо:	
10	Холбоо барих утас:	
11	Байрлах хаяг:	
12	Хүсэлт гаргасан:	_____ /Гарын үсэг/
		_____ /Гарын үсгийн тайлал/
13	Зөвшөөрсөн ДТГ-ын тэргүүн:	_____ /Гарын үсэг/
		_____ /Гарын үсгийн тайлал/
ДТГ-ЫН БӨГЛӨХ ХЭСЭГ		
14	Зөвшөөрсөн:	_____ /Гарын үсэг/
		_____/_____/_____ /огноо/
15	Татгалзсан:	_____ /Гарын үсэг/
		_____/_____/_____ /огноо/
16	Бүртгэл хариуцсан ажилтан хүлээн авсан:	_____ /Зөвшөөрлийн дугаар/
		_____/_____/_____ /огноо/
<p>Санамж: ДТГ-ын тэргүүн өөрийн зорчих зөвшөөрөл хүсэхдээ 13 дахь хэсгийг бөглөхгүй, 12 дахь хэсэгт гарын үсэг зурж ирүүлнэ. Тус мэдэгдэх хуудсыг үнэн зөв бөглөөгүй, холбогдох зөвшөөрөл авалгүй суугаа болон хавсран суугаа улсаас өөр улс болон эх орондоо зорчсон тохиолдолд "Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм"-д заасны дагуу хариуцлага тооцохыг анхаарна уу.</p>		